



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 14 өдөр

Дугаар А/665

Есөнбулаг

Шуурхай штаб байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дугаар зүйлийн 27^{1.2}, 27^{1.3} дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны 279 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2023 оны "Шуурхай штаб байгуулах тухай" 08 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөлжилтийг даван туулах, цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, хор уршгийг арилгах, холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор аймгийн Онцгой комиссын Шуурхай штабыг байгуулж ажиллуулсугай.

2.Шуурхай штабын бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, ажиллах түр журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Шуурхай штабын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Онцгой комиссын орлогч (Г.Чинбат)-д, шуурхай штабын үйл ажиллагааг хэрэгжүүлж, хамтран ажиллахыг сум, байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4.Шуурхай штабт шаардагдах зардлыг тухай бүр шийдвэрлүүлж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой комиссын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



ОАМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2019 оны
19 дугаар сарын 14-ны өдрийн 66 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ШУУРХАЙ
ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮН

ДЮЛ0042

Дарга:	Г.Чинбат	(аймгийн Засаг даргын орлогч)
Орлогч дарга:	Т.Сүхбаатар	(Хүнс хөдөө, аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүд:	Ш.Эрдэнэбат	(аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)
	С.Мөнхжаргал	(Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
	Х.Баатарзориг	(Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
	Н.Хаш-Эрдэнэ	(Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)
	Д.Төмөрбаатар	(аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа)
	Н.Энхбаяр	(Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийн захирагч, хурандаа)
	Н.Мэндбаяр	(Цагдаагийн газрын дарга, хурандаа)
	Г.Болдбаатар	(Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Г.Лхагважаргал	(Эрүүл мэндийн газрын дарга)
	Р.Бүрэнбаясах	(Мал эмнэлгийн газрын дарга)
Д.Батгайван	(Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)	
Д.Тунгалаг	(Статистикийн хэлтсийн дарга)	
Н.Алтантуяа	(Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга)	
С.Гантулга	(Авто тээврийн төвийн дарга)	
Ч.Батзориг	Сумдын Засаг дарга нар (Улаан загалмайн хорооны дарга)	
Нарийн бичиг:	Ц.Амарсанаа	(Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, хошууч)

__оОо__

Аймгийн Засаг даргын 2024 оны
12 дугаар сарын 14 ны өдрийн 66 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ ШУУРХАЙ ШТАБЫН АЖИЛЛАХ ТҮР ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтыг даван туулах, цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, хор уршгийг арилгах, тэдгээрийг удирдлага зохион байгуулалтаар хангах аймгийн Засаг даргын дэргэдэх байнгын ажиллагаатай Шуурхай штаб (цаашид "Шуурхай штаб" гэх)-ын үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Шуурхай штаб нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Нөөцийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр Улсын Их Хурал, Засгийн газар, Улсын онцгой комиссоос гаргасан тогтоол, шийдвэр, зөвлөмжийг мөрдлөг болгон ажиллана.

Хоёр. Шуурхай штабын удирдлага, зохион байгуулалт

2.1. Аймгийн Онцгой комиссын дарга Шуурхай штабыг бодлого, стратегийн удирдлагаар хангана.

2.2. Шуурхай штабын өдөр тутмын үйл ажиллагааг штабын дарга удирдан зохион байгуулж ажиллана.

2.3. Шуурхай штаб нь аймаг, сумын Онцгой комиссын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, ажиллана.

2.4. Шуурхай штабын бүрэлдэхүүнд 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдалтай уялдуулан шаардлагатай тусгай чиг үүрэг бүхий байгууллага болон холбогдох төрийн байгууллагын мэргэжлийн шийдвэр гаргах түвшний албан хаагчийн төлөөллийг ажиллуулна.

2.5. Шуурхай штабын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, гарсан шийдвэр, иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод байна.

2.6. Шуурхай штабын бүрэлдэхүүний ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, хэрэгжүүлэх арга хэмжээнээс хамаарч ажлын цагийн зохицуулалт, зохион байгуулалтын арга хэмжээг Шуурхай штабын дарга авч хэрэгжүүлнэ.

2.7. Шаардлагатай үед штаб нь хуралдах ба хурлын зарыг штабын нарийн бичгийн дарга хүргэж, хурлын тэмдэглэлийг хөтлөнө.

Гурав. Шуурхай штабын хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Шуурхай штаб нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж, үр дүнг аймгийн Засаг даргад тайлагнан ажиллана.

3.1.1. Аймгийн өвөлжилтийн төлөвлөгөө болон аймгийн Онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, шуурхай зохион байгуулах хяналт тавих, тайлагнах;

3.1.2. Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах, үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх хариу арга хэмжээг хүн амын эрүүл мэнд,

нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан төлөвлөж зохион байгуулах;

3.1.3.Өвс, тэжээл, хоол, хүнс, эм, эмнэлгийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний нөөцийн судалгааг гаргах, хангалтыг зохион байгуулах;

3.1.4.Иргэдийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хариу өгөх арга хэмжээг зохион байгуулах;

3.1.5.Иргэдийг мэдээ мэдээллээр хангаж ажиллах;

3.1.6.Аймгийн онцгой комиссын дарга болон гишүүдийг мэдээ мэдээллээр тогтмол хангаж ажиллах;

3.2.Байнгын ажиллагаатай Шуурхай штабын дарга, гишүүд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллана.

3.2.1.Шуурхай штабын даргын баталсан хуваарын дагуу гишүүд шуурхай штабт 09:00-18:00 цагийн хооронд ажиллах;

3.2.2.Сумдаас өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдлын мэдээг тогтмол авах, газрын зурагт оруулах;

3.2.3. Шуурхай штабын хуралдаанд оролцох, зар хүргэх;

3.2.4.Өвөлжилт хаваржилтын нөхцөл байдалтай холбогдуулан судалгаа хийх, тоон мэдээлэл дээр дүн шинжилгээ хийж ажиллах;

3.2.5.Шаардлагатай тохиолдолд Аймгийн Онцгой Комисст саналаа танилцуулж танхимаар болон цахимаар хуралдуулах;

3.2.6.Холбогдох тайлан мэдээг УОК-т хүргүүлж ажиллах;

3.2.7.Шуурхай штабын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг үнэлэх, тайлагнах;

3.2.8.Сум, байгууллагын бэлэн байдлыг хангуулах, заавар, зөвлөмж өгөх;

3.2.9.Бүлгүүдийн тогтвортой ажиллагааг хангах, гишүүдийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, ажлын хариуцлага дэг журмыг сахиулах;

3.2.10. Шуурхай штабын даргыг мэдээ мэдээллээр хангах;

3.2.11.Штабын даргын өгсөн үүрэг, даалгавар, шийдвэрийн хэрэгжилтийг хангах;

3.2.12.Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах, үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх тэмцэх чиглэлээр болон Шуурхай штабын үйл ажиллагаатай холбоотой журам, заавар, зөвлөмж, төлөвлөгөөний төсөл, танилцуулга зэрэг бодлогын болон техникийн баримт бичгийг боловсруулж, батлуулах;

3.2.13.Иргэдийн санал, гомдол, шүүмжлэлийг нэгтгэн дүн шинжилгээ хийх, холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжлан шийдвэрлүүлэх;

Дөрөв.Бусад зүйл

4.1.Штабын бүрэлдэхүүн нь төрийн албан хаагчийн ёс зүйг баримтлан авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ.

4.2.Штаб нь ажлын тусгай горимоор буюу уртасгасан цагаар ажиллаж болно.

4.3.Штабын бүрэлдэхүүнд ажиллаж байгаа албан хаагчдын илүү цагаар ажилласан цагийн бүртгэлийг үндэслэн холбогдох байгууллагын удирдлага тухайн ажилтанд нэмэгдэл хөлс, шагнал, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэнэ.

4.4. Энэхүү журмыг зөрчсөн, үүргээ зохих ёсоор биелүүлээгүй албан хаагчид холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох саналыг тухайн алба хаагчийн харьяалах байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлнэ.

-oOo-